

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: С.Нурлан Утас: 94209011 Цахим хаяг: nurlans@ audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
Байхгүй	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

МОНГОЛ АЛТАЙН ХАДНЫ ЗУРГИЙН
ЦОГЦОЛБОРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА Б.ӨМИРБЕК ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.14 № 43
танай -ны № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

MAX3ЦX3-dugnelt-2.07-TA

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

MAX3ЦХ3-dugnelt-2.07

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>0.00</u>	<u>15081700.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	15081700.00
351	Түүхий эд материал	0.00	0.00
354	Хангамжийн материал	0.00	15081700.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	15081700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>0.00</u>	<u>7608061.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	7608061.98
392	Биет хөрөнгө	0.00	6630562.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	3600700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-360231.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	2858451.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-166742.80
39217	Ном	0.00	698385.00
393	Биет бус хөрөнгө	0.00	977499.97
39301	Програм хангамж	0.00	1150000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-172500.03
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>0.00</u>	<u>22689761.98</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>0.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>0.00</u>	<u>22689761.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	22689761.98
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	22689761.98
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	0.00
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	22689761.98
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.00	0.00
51600	Нөөцийн сан	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>0.00</u>	<u>22689761.98</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	201,730,536.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,962,236.50
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,962,236.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	4,962,236.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	4,962,236.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	196,768,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,257,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,257,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	194,510,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	194,510,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	179,040,774.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	179,040,774.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	133,049,463.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	85,582,858.10
210101	Үндсэн цалин	-	72,562,026.00
210102	Нэмэгдэл	-	8,507,662.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,513,170.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	11,064,841.00
210201	Тэтгэврийн даатгал	-	7,641,526.24
210202	Тэтгэмжийн даатгал	-	855,829.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	684,661.81
210204	Ажилгүйдлийн даатгал	-	171,165.38
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,711,658.38

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,513,500.00
210304	Байрны түрээс	-	3,513,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,804,070.00
210401	Бичиг хэрэг	-	282,200.00
210402	Тээвэр, шатахуун	-	957,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	282,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	282,200.00
2105	Нормативт зардал	-	2,257,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,257,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	28,127,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	27,877,120.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	699,474.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	699,474.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	45,991,310.90
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	45,991,310.90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,991,310.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	<u>22,689,761.98</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	<u>22,689,761.98</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		0.00
C07	Тайлант үеийн үр дүн		0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.00
D08	Тайлант үеийн үр дүн	22,689,761.98	22,689,761.98
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,689,761.98	22,689,761.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	196768300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	196768300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	194510700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		194510700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2257600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2257600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	193423000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	193423000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	147431689.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	85582858.10
210101	Үндсэн цалин	0.00	72562026.00
210102	Нэмэгдэл	0.00	8507662.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	4513170.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	11064841.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	7641526.24
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	855829.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	684661.81
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	171165.38
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	1711658.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	3513500.00
210304	Байрны түрээс		3513500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	1804070.00
210401	Бичиг хэрэг	0.00	282200.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	957470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	282200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	282200.00
2105	Нормативт зардал	0.00	2257600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2257600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	43208820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	42877120.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		331700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	45991310.90
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	45991310.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	45991310.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>0.00</u>	<u>3345300.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	3345300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	3345300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	3345300.00
222001	Тоног төхөөрөмж		3345300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>0.00</u>	<u>-3345300.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	194510700.00	150776989.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	194510700.00	150776989.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194510700.00	150776989.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124527400.00	85582858.10
210101	Үндсэн цалин	94527400.00	72562026.00
210102	Нэмэгдэл	25000000.00	8507662.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5000000.00	4513170.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16811200.00	11064841.00
210201	Тэтгэврийн даатгал	11830100.00	7641526.24
210202	Тэтгэмжийн даатгал	1245300.00	855829.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	996200.00	684661.81
210204	Ажилгүйдлийн даатгал	249100.00	171165.38
210205	Эрүүл мэндийн даатгал	2490500.00	1711658.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3513500.00	3513500.00
210304	Байрны түрээс	3513500.00	3513500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2055200.00	2053070.00
210401	Бичиг хэрэг	282200.00	282200.00
210402	Тээвэр, шатахуун	959600.00	957470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	282200.00	282200.00
210404	Ном, хэвлэл	249000.00	249000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282200.00	282200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	0.00	2257600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	2257600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3096300.00	3096300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3096300.00	3096300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44507100.00	43208820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42910000.00	42877120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	663900.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	326000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	331700.00	331700.00
210807	Газрын төлбөр	275500.00	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152010700.00	154268300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	152010700.00	152010700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	152010700.00	152010700.00

14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	2257600.00
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		2257600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	11.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	4.00
620004	Гэрээт ажилтан	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.0	11.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2257600.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2257600.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2257600.00	
2105	Нормативт зардал	0.00	2257600.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2257600.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	2257600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2257600.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2257600.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь хамгаалалтын захиргааны газар нутаг дахь түүх, соёлын дурсгал, соёлын өв, археологийн дурсгалын бүртгэл судалгааг хийх, баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилго, зорилтыг дэвшүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны Дотоод аудит эрсдэлийн удирдлагын газраас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийж заавар, зөвлөгөө өгч ажилладаг байна. Тус газарт 2021 онд дээрх газраас дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 55,7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1,1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 0,9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй ба 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 22,7 сая төгрөг байна. 2021 оны эхний хагас жилийн үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	00	15,081.7	15,081.7
Үндсэн хөрөнгө	00	7,608.1	7,608.1
Нийт хөрөнгө	00	22,689.8	22,689.8
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	00	22,689.8	22,689.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	00	22,689.8	22,689.8

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд 22.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 8.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд 3.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 4.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 0.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Авлага, өр төлбөрийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22.7 сая төгрөг болж 22.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 22.7 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 201.7 сая төгрөг ба өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй тул 201.7 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй ба нэмэлт санхүүжилтийн орлого 2.2 сая төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн 2.2 сая төгрөгөөр ажилчдад нормын хувцас худалдан авсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 202,6 сая төгрөг, тодотгосон төсөв 194.5 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 8.1 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: хангамж бараа материалын зардлыг 0.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 7.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 0.2 сая төгрөгөөр бууруулж, нийтдээ 8.1 сая төгрөгөөр тодотгол хийгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 194.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 148.6 сая төгрөгийг зарцуулжээ. Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төсвийг нийт дүнгээр 46.0 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Хэмнэлттэй гарсан зардлууд нь: Цалингийн зардлыг 44.6 сая, Тээвэр, шатахуун болон Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжаас 1.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой мэдээллүүдийг бүрэн толилуулан, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус газрын 2021 оны батлагдсан төсвийн 10 хувь 19.4 сая төгрөг бөгөөд 46.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна гэж үзлээ.

Тус захиргаа нь 2020 онд шинээр байгуулагдан 2021 оноос үйл ажиллагаа явуулсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлуудыг төсвийн ерөнхий захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2021 онд нийт 194.5 сая төгрөгийн 119 мэдээллийг тус байгууллагын шилэн дансны тайлан илгээх маягтаар хянаж үзэхэд мэдээлсэн 75, мэдээлээгүй 30, хугацаа хоцроосон 14 үзүүлэлтэй байна. Мэдээлээгүй шалтгаан нь тус байгууллага үйл ажиллагаагаа 2021 оны 2 дугаар сараас эхлэн явуулсантай, мөн шилэн дансны эрхийг 4 дүгээр сард нээсэнтэй холбоотой байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагын хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгийн маягтаар мэдээлсэн 75 хувь, мэдээлээгүй 4.2 хувь, хугацаа хоцроосон 20.8 хувьтай ба зөрчлийн шийдэлд хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь болох 20.8 хувийг харгалзан үзэж нийт шилэн дансны хэрэгжилтийг 95.8 хувьтай буюу хангалттай гэж үзлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 7.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд "Нурбах" ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлсэн 7.5 сая төгрөгийн 10 ширхэг багана, 10 ширхэг сурталчилгааны самбарыг бараа материал дансанд орлого авахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна. Аудитын явцад бараа материалын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, санхүүгийн байдлын тайланд тус тус залруулга хийлгэж, алдаа зөрлийг арилгуулав.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа	1	7.5	1	7.5						